

ДУНДГОВЬ АЙМГИЙН ЛУУС СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ
2018 – 2019 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН 1, 2 ДУГААР УЛИРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

2018.11.15

Зорилт	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин гүйцэтгэлийн хувиар	Хэрэгжилт	Хувь
Боловсролын удирдлага менежментийг сайжруулах чиглэлээр : Сургалтын чанарт ахиц гаргах, арга зүйн хөгжлийг дэмжсэн таатай орчныг бүрдүүлж, хичээл сургалтын өдөр тутмын үйл ажиллагааг чанартай бэлтгэн зохион байгуулахад багшид дэмжлэг үзүүлнэ.				
<p>1. Бүх шатны боловсролын сургалт, хүмүүжлийн ажлын агуулга, аргазүйн уялдаа холбоог сайжруулах, сургалтын чанар, үр өгөөжийг дээшлүүлэх, суралцагчийн эрүүл аюулгүй орчинд сурч хөгжих нөхцөл боломжийг нэмэгдүүлнэ.</p>	<ul style="list-style-type: none"> ❖ 1-5 дугаар ангийн сурагчдын унших чадварт “Flat” аргачлалд тулгуурлан судалгаа хийж унших, ойлгох, ярих, бичих чадварт ахиц гаргана ❖ Хоцрогдолтой сурагчдын судалгаа бүх хичээлээр хийх, судалгаанд суурилан сурагчдын хоцрогдол арилгах сургалт хичээлийн бус цагаар явуулах ❖ Бага, дунд ангийн сурагч бүр бүтээлийн сантай болж хагас жил тутамд үзэсгэлэн гаргах ❖ Бүх хичээлээр шалгалтын сантай болох ❖ Бүх хичээлээр нэгж хичээлийн хөтөлбөр болвсруулж, сурагчдын хэрэгцээ, сонирхол, онцлог байдлыг тооцож жил бүр агуулга, арга зүйгээ сайжруулах ❖ Ээлжит хичээлийн бэлтгэлд илүү анхааран, хичээл бүрийг үр өгөөжтэй зохион байгуулах ❖ Сургууль, дотуур байрын орчинд эрсдлийн үнэлгээг 1 болон 3 дугаар улиралд зохион байгуулж, үнэлгээний үр дүнд тулгуурлан орчны эрсдлийг бууруулан ажиллах 	<ul style="list-style-type: none"> ❖ Бага боловсролын үнэлгээний дундажыг 63,9 - 70 хувьд хүргэх ❖ Суурь боловсролын үнэлгээний дундажыг 70,9 - 75 хувьд хүргэх ❖ Массын олимпиадын амжилтаар эхний 10 – т жагсах ❖ Бид чадна аяны гүйцэтгэлийг 60,7 – 80 хувьд хүргэх ❖ Сургууль дотуур байрын орчны эрсдэлийн үнэлгээний үр дүнг “бага эрсдэлтэй” 	<p>2-5 дугаар ангийн 71 сурагчдын унших, ярих чадварт судалгаа хийхэд үг уншдаг 2, цогцолборын түвшний 3, эхийн түвшний 24, эх уншаад ойлгосноо ярих түвшний 17, орон нутгийн нийтлэл уншаад ойлгосноо ярих чадвартай сурагчид 13 байсан ба судалгааны мөрөөр багш нар ажлын төлөвлөгөө гарган ахиц өөрчлөлтийн судалгаатай ажиллаж байна. Дээрх үйл ажиллагааны мөрөөр сургалтын менежер болон ЗАН-ийн ахлагч нар сурагчдын унших ойлгон ярих чадварт сар бүр ахиц өөрчлөлтийн судалгаатай ажиллан үр дүнг багш нарын ажлын үзүүлэлтэнд оруулан тооцож ажиллаж байна. Бүх сурагчдыг бүтээлийн хавтастай болгосон ба мэргэжил сурталчилах 7 хоногийн хүрээнд бага, дунд ангийн 132 сурагчдын бүтээлийг эцэг эх олон нийтэд сурталчилан таниуллаа. Ахмад багш Ч.Нямаагийн зөвлөгөөгөөр Дэлгэрцогт, Өлзийт сумын сургуулийн багш нартай хамтран 2 дугаар улирлын хөтөлбөр боловсруулан туршиж хэрэгжүүлэх ажлыг эхлүүлээд байна.</p>	<p align="center">70</p>
<p>2. Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийг</p>	<ul style="list-style-type: none"> ❖ Багшийн хөгжил хөтөлбөр боловсруулна ❖ Эцэг эх, багш нарт хуулийг 	<ul style="list-style-type: none"> ❖ 34 багш ажилтан, 100 эцэг эхэд багшийн хөгжлийн 	<p>Багшийн хөгжил хуулийн сургалтыг 34 багш, ажилтан, 80 гаруй эцэг эхчүүдэд зохион байгуулж хуулийн онцлог, үр</p>	<p align="center">70</p>

<p>хэрэгжүүлэх бэлтгэлийг хангаж боловсролын байгууллага бүр идэвхитэй ажиллана.</p>	<p>сурталчилан хэрэгжилтэнд үнэлгээ дүгнэлт хийх</p>	<p>хуулийг сурталчилан таниулсан байна.</p>	<p>дүнг сурталчтлан таниуллаа. Мөн Багшийн хөгжил хөтөлбөрийг хамт олны хурлаар хэлэлцүүлэн баталлаа.</p>	
<p>3. Хүүхдийн хөгжлийн онцлог, соёл, амьжиргааны түвшнээс үл хамааран тэгш хамруулан сургах бэлэн байдлыг сургалтын байгууллагад хангана.</p>	<p>❖ Өрхийн хэрэгцээний болон өвөлжилтийн бэлтгэл хангалтын судалгааг анги удирдсан багш нартай хамтран хийж, нийгмийн халамж дэмжлэг шаардлагатай, дотуур байранд хамруулах сурагчдыг холбон зуучлах</p>	<p>❖ 138 суралцагчийн ар гэрт нөхцөл байдлын үнэлгээг хийж, дэмжлэг шаардлагатай суралцагчдыг нийгмийн тусламж үйлчилгээнд холбон зуучилсан байна.</p>	<p>2018 оны 09 – 10 сарыг дуустал нийт 138 суралцагчийн өвөлжилтийн бэлтгэл хангалт, ар гэрийн нөхцөл байдалд үнэлгээ хийн, эрсдэлийн үнэлгээний судалгааг авлаа. Судалгааны нэгтгэлээс дүгнэхэд нийгмийн халамж дэмжлэг шаардлагатай 31, өндөр эрсдэлтэй 0, дунд эрсдэлтэй 4 суралцагч байна. Зайлшгүй анхаарах шаардлагатай, эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа 9 сурагчийг дотуур байранд хамруулан ажиллаж байна.</p>	<p>70</p>
<p>4. Багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангах, мэргэжил дээшлүүлэх онлайн сургалт, боловсролын нээлттэй эх үүсвэрийг хөгжүүлэх техникийн нөхцөл боломжийг сайжруулж, хүний нөөцийг бэлтгэхэд хариуцлагатай хандана.</p>	<p>❖ Онлайн сургалтанд багш нар, удирдлагуудыг хамруулах ❖ Багш бүр хувийн хөгжлийн төлөвлөгөөгөө хэрэгжүүлж, хагас жил тутамд төлөвлөгөөний хэрэгжилтэд үнэлгээ дүгнэлт хийх</p>	<p>❖ Онлайн сургалтанд 10 багш, ажилтныг хамруулна. ❖ Хувийн хөгжлийн төлөвлөгөөг 14 багш гаргаж, хэрэгжилтийг тооцон ажилласан байна.</p>	<p>БСШУСЯ-аас хэрэгжүүлж буй “Бага ангийн сурагчдын унших, бичих, ярих чадварыг нэмэгдүүлэх сургалтанд 6 багш, Хөтөлбөрт суурилсан арга зүй сургалтанд 1 багш, 1 удирдлага, Хөгжлийн дэмнэл ТББ-аас хэрэгжүүлж буй мэдээллийн технологи, англи хэлний сургалтанд 2 багш, 1 удирдлага, Залуу багш нарын зөвлөгөөнд 2 багш, 1 удирдлага, Хөтөлбөр боловсруулах сургалтанд 9 багш, Эрүүл мэндийн хичээлийн сургагч багш бэлтгэх сургалтанд 2 багш нийт 25 багш, ажилтанг сургалтанд хамруулсан ба 1,5,10 дахь жилдээ ажиллаж буй багш, ажилтан, удирдах ажилтны мэргэжил дээшлүүлэх сургалтанд 3 багш, 2 ажилтан, 1 удирдах ажилтанг тус тус</p>	<p>70</p>

			хамруулахаар БМДИ-д хүргүүлээд байна.	
5. Боловсролын байгууллага ёс зүйн зөрчлөөс ангид байхыг эрхэмлэн багш ажилтан бүр ёс зүйн дүрмийг үйл ажиллагаандаа чанд мөрдөнө.	<ul style="list-style-type: none"> ❖ Багш, ажилчидтай ёс зүйн гэрээ байгуулж хэрэгжилтэнд нь хяналт тавьж ажиллах ❖ Ёс зүйн талонтой болох ❖ МУЗГ – ын 258 дугаар тогтоол, багшийн ёсзүйн дүрмийг мөрдлөг болгон, багш ажилтнуудад ёс зүйн аливаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл сургалтыг тогтмол зохион байгуулах. 	<ul style="list-style-type: none"> ❖ Өмнөх хичээлийн жилд ёсзүйн үнэлгээ 96,6 хувьтай байсныг 100 хувьд хүргэж, ёсзүйн зөрчилгүй хамт олон бүрдүүлнэ. 	МУЗГ – ын 258 дугаар тогтоол, БСШУСЯамны сайдын А/243 дугаар тушаалыг тус тус багш ажилтнууддаа танилцуулах сургалтыг зохион байгуулж, дотоод журам, хөдөлмөрийн гэрээ, ажлын байрны тодорхойлолтонд тус тус холбогдох заалтуудыг тусган шинэчиллээ. Мөн ажлын байрны онцлогтой уялдуулан сахилга хариуцлагын гэрээг 6 галчтай байгуулсан. 2018.11.06 – ны өдрийн А/26 тоот сургуулийн захирлын тушаалаар ёс зүйн зөвлөлийг шинэчлэн байгуулж, 2018.11.07 – ны өдөр зохион байгуулагдсан нээлттэй хаалганы өдөрлөгөөр багш ажилтнуудын ажлын цаг ашиглалт, ёс зүйн үнэлгээг авахад ажлын цаг ашиглалт 92 хувь, ёсзүйн үнэлгээ 95,7 хувьтай тус тус үнэлэгдсэн ба нэр заасан хоёр санал ирснийг сургуулийн захиргаанд танилцуулан, холбогдох багш ажилтнуудад сануулга өглөө.	100
Ерөнхий боловсролын сургалтын байгууллагын түвшинд : Суралцагчийн онцлог, ялгаатай байдлыг харгалзан хичээл бүрийг заах аргын нэгдэл, секцээр чанартай бэлтгэн, үр дүнтэй зохион байгуулж, суралцагчийн суралцах идэвхийг урамшуулан дэмжих замаар сурлагын чанарт ахиц гаргана.				
6. Сургалт хүмүүжлийн ажлыг төлөвлөх, бэлтгэх, зохион байгуулах, үнэлэх ажлыг хамтын оролцоотой хэрэгжүүлнэ.	<ul style="list-style-type: none"> ❖ Ажлын төлөвлөгөөг сараар гаргаж хэрэгжилтэнд хяналт тавих ❖ Урилгат хичээл зохион байгуулах ❖ Сургуулийн нэгдсэн хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж, хөтөлбөрийг сайжруулна ❖ Эцэг эхчүүдэд сурагчдын сурлагын амжилт, ирц зэрэг мэдээллийг parent.esis.edu.mn сайтаар 	<ul style="list-style-type: none"> ❖ Урилгат хичээл – 30 ❖ Нийт эцэг эхийн хурал, өдөрлөг - 2 ❖ Мэргэжил сурталчилах 7 хоног – 1 удаа бүх судлагдахуунаар ❖ Цахим бүртгэл 144 	Мэргэжил сурталчилах 7 хоногийн хүрээнд Сурагчдын бүтээл, ололт амжилтыг 14 багш, 138 суралцагч, 50 гаруй эцэг эхэд сурталчилан таниуллаа. Ахмад багш Ч.Нямаатай хамтран бага, дунд ангийн 14 багш 2 дугаар улирлын хөтөлбөрийг боловсруулан сургалтандаа ашиглаж байна.	70

	дамжуулан хүргэх	эцэг эхийг тус тус хамруулж, хамтран ажиллах	138 эцэг эхэд мэйл хаяг нээн сурагчдын сурлагын ахиц өөрчлөлт, гэрийн даалгавар, хүмүүжил төлөвшлийг 7 хоног бүр мэдээллэх нөхцөлийг бүрдүүлсэн.	
7. Монгол хэл, уран зохиол, орос, англи хэл, мэдээллийн технологийн сургалтаар суралцагчийн эзэмших мэдлэг, чадварт онцгойлон анхаарч, багшийн аргазүйг хөгжүүлнэ.	<ul style="list-style-type: none"> ❖ Хөндлөнгийн үнэлгээг сар тутам хийж ахиц өөрчлөлтийг тооцож ажиллах ❖ 7 хоногт 3-аас доошгүй удаа багш нарын хичээл үйл ажиллагаанд сууж зөвлөн туслах ❖ Багш бүрт Блүүмийн таксономоор сорил даалгавар боловсруулах чадварт анализ хийх 	<ul style="list-style-type: none"> ❖ Ээлжит хичээлд 30 удаа /давхардсан тоогоор/ суух, судлагдахуун бүрийн гүйцэтгэлийг аймгийн дунджаас 2 хувиар ахиулна. 	Гадаад хэлний хичээлийг, сургалтын хөтөлбөрийн дагуу зохион байгуулж, 14 хоног бүр Блүүм таксономын аргаар материал боловсруулж өөрийн үнэлгээ болон хөндлөнгийн үнэлгээ хийж сурагчдын ахиц өөрчлөлтийг тухай бүр тооцож байна. Мөн сургалтын чанарыг сайжруулах үүднээс 1-р улирлын амралтаар зөвлөх багш Ч.Нямаагаас арга зүйн зөвлөгөө авч, Өлзийт, Дэлгэрцогт сумдын багш нартай хамтран 5-9-р ангийн цагчилсан хөтөлбөр боловсруулан сургалтандаа туршиж сайжруулан ажиллаж байна. Үүний үр дүнд 5-9-р ангийн сурлагын амжилт 5-13.5%, чанар 12-17%иар ахисан үзүүлэлтэй байна. Сургалтын менежерийг 7 хоногт 1 удаа хичээлдээ суулгаж аргазүйн зөвлөгөө авч сургалтандаа тусгаж аргазүйгээ сайжруулан ажиллаж байна. Онолын мэдлэг болон заах арга зүйгээ сайжруулах үүднээс сургалт семинарт тогтмол хамрагдаж байна. БСУГ-аас зохиогдсон онол аргазүйн 3 өдрийн сургалт, Блүүм таксономоор сорилго даалгавар боловсруулах чадварт анализ хийх, Эрхүү хотноо зохион байгуулагдсан Орос хэлний багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтуудад тус тус хамрагдлаа. Монгол хэл, монгол бичиг, уран	70

			<p>зохиолын хичээлийг сургалтын хөтөлбөрийн дагуу зохион байгуулж, 14 хоног бүр Блүүм таксономын аргаар материал боловсруулж өөрийн үнэлгээ болон явцын үнэлгээ хийж сурагчдын ахиц өөрчлөлтийг тухай бүр тооцож байна. Мөн сургалтын чанарыг сайжруулах үүднээс 1-р улирлын амралтаар зөвлөх багш Ч.Нямаагаас арга зүйн зөвлөгөө авч, Өлзийт, Дэлгэрцогт сумдын багш нартай хамтран 6-9 ангийн Монгол хэл, Монгол бичиг, Уран зохиолын хичээлийн цагчилсан хөтөлбөр боловсруулан сургалтандаа туршиж хэрэгжүүлэн сайжруулж байна. Үүний үр дүнд 6-9 ангийн сурлагын амжилт 10-20%, чанар 15-20%иар ахисан үзүүлэлттэй байна. Сургуулийн графикт үйл ажиллагаа болон уралдаан тэмцээнд тогтмол оролцохоор бэлтгэл ажилдаа ороод байна. Монгол бичгийн хичээлийн сургалтын чанарыг ахиулах үүднээс Ардын багш Төмөрийн “Монгол бичиг 15 хоногт сурах нь” сэдэвт гарын авлага номыг 6 ангийн нийт 18 сурагчдад захиалан авч сургалтын үйл ажиллагаандаа ашиглаж байна. Дунд ангийн багш нарын “Мэргэжил сурталчлах 7 хоног “аяны хүрээнд Кирил бичиг болон монгол бичгийн хуулан бичлэгийн уралдаан, ”Уран бичлэг, “Уран уншлага, ”Үсэглэлийн хаад” танин мэдэхүйн тэмцээнийг ТАХ, иргэд,олон нийт, эцэг эх, сурагчдын дунд удирдамж боловсруулан БАЗАН-ийн багш нартай хамтран зохион байгуулахаар төлөвлөөд байна.</p>	
--	--	--	--	--

<p>8. Эрүүл мэнд, аюулгүй амьдрах ухааны сургалтын хөтөлбөрийг ерөнхий боловсролын сургуульд хэрэгжүүлж эхэлнэ</p>	<ul style="list-style-type: none"> ❖ 7 хоногт 3-аас доошгүй удаа багш нарын хичээл үйл ажиллагаанд сууж зөвлөн туслах ❖ Хөндөнгийн үнэлгээг сар тутам хийж ахиц өөрчлөлтийг тооцож ажиллах ❖ Сургуулийн нэгдсэн хөтөлбөртэй болох ❖ Мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах 	<ul style="list-style-type: none"> ❖ Ээлжит хичээлд 14 удаа сууж, мэргэжлийн байгууллагатай хамтран 2 удаагийн үйл ажиллагаа зохион байгуулж, нэгдсэн сургуулийн хөтөлбөртэй болсон байна. 	<p>Эрүүл мэндийн хичээлийг сургалтын хөтөлбөрийн дагуу, зохион байгуулж, 14 хоног бүр Блүүм таксаномийн аргаар ээлжит хичээл болон материалууд боловсруулан өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг хийж сурагчдын ахиц амжилтыг тухай бүр үнэлж байна. Сургалтын чанарыг сайжруулах үүднээс 1-р улирлын амралтаар зөвлөх багш Ч.Нямаагаас арга зүйн зөвлөгөө авч, Өлзийт, Дэлгэрцогт сумдын багш нартай хамтран 6-9 ангийн Эрүүл мэндийн хичээлийн цагчилсан хөтөлбөр боловсруулан сургалтандаа туршиж хэрэгжүүлэн сайжруулж байна. Сурагчдын сурлагын амжилтыг 15-20%-иар ахиулах төлөвлөгөөтэй ажиллаж байна. Мөн сургалтын нэгдсэн хөтөлбөртэй болон хөтөлбөр төлөвлөгөөнийхөө дагуу ажиллаж байна. Сумын эрүүл мэндийн төвтэй хамтран ажиллаж, нэмэлт тараах материал болон сургалт зохион байгуулахад хамтран ажиллаж байна.</p>	<p>70</p>
<p>9. Сургалтын байгууллага, багш, суралцагчийг үнэлэх үнэлгээний шинэчлэлийг эрчимжүүлж, сургуулийн үйл ажиллагаанд өөрийн болон хөндлөнгийн үнэлгээний тогтолцоог</p>	<ul style="list-style-type: none"> ❖ Судлагдахуун бүрээр багш бүр 7 хоног, ЗАН 14 хоногт, сургууль 21 хоногт үнэлгээ хийж ахиц өөрчлөлтийг тооцож ажиллах ❖ Үнэлгээний журмыг эцэг, багш, сурагчдыг танилцуулж хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллах ❖ БСУГ-ын мэргэжилтэнгүүдтэй хамтран ажиллах 	<ul style="list-style-type: none"> ❖ Үнэлгээний шинэчилсэн журмыг 138 эцэг эх, 34 багш ажилтанд танилцуулж, судлагдахуун бүрээр 4 удаагийн хөндлөнгийн үнэлгээг хийсэн байна. 	<p>Судлагдахуун бүрээр өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг сургуулийн онцлогт тулгуурлан хийж хэвшсэн ба үнэлгээний мөрөөр багш бүрээр сурлагын ахиц амжилтыг тооцон ажлын үзүүлэлтэнд оруулан тооцож хэвшлээ. БСШУСЯ-ны сайдын А/425 дугаар тушаалын онцлог, ялгаа, давуу талыг “Эцэг эхийн нэгдсэн өдөрлөг”, “Ангийн эцэг эхийн хурал”, “3 багийн нэгдсэн өдөрлөг”-ийн үеэр 120 гаруй эцэг эхчүүдэд танилцуулж гарын авлага</p>	<p>70</p>

нэвтрүүлнэ.			тараасан. Мөн 132 сурагчдад үнэлгээний онцлог, давуу талын талаар танилцууллаа. БСУГ-ын мэргэжилтэнгүүдтэй хамтран байгалийн ухаан, бага ангийн математик, монгол хэлний хөндлөнгийн үнэлгээ зохион байгуулсан ба 4 нэгж хичээлийн боловсруулалт, 5 ээлжит хичээлийн зөвлөгөөг авч ажиллалаа.	
10. Дунд, ахлах ангийн сурах бичгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, эцэг эх, асран хамгаалагчаас хүүхдийн сурах бичиг худалдан авахад зарцуулж буй зардлыг бууруулах зорилгоор сурах бичгийн түрээсийн тогтолцоог нэвтрүүлнэ.	<ul style="list-style-type: none"> ❖ БСУГ – т хүүхдийн тоогоор сурах бичгийг урьдчилан захиалж, хичээлийн жилийн эхэнд сурах бичгээр бүрэн хангах ❖ Дунд ангийн сурагчдын худалдан авах сурах бичгийн захиалгыг сумын шуудангийн ажилтантай хамтран, чирэгдэлгүйгээр шуурхай захиалах боломжоор хангах. 	<ul style="list-style-type: none"> ❖ Сурах бичгийн хангалтыг дунд ангид эцэг эх, анги удирдсан багш, холбооны ажилтантай хамтран 90 хувьд хүргэх 	1-5 дугаар ангийн сурагчид сурах бичгээр 100 хувь хангагдсан. Дунд ангийн сурагчдын номын захиалгыг шуудангийн ажилтанд хүргүүлж ажилласнаар сурах бичгийг чирэгдэлгүйгээр шуурхай захиалах боломж бүрдсэн.	100
11. Ерөнхий боловсролын сургууль, дотуур байрын сургалтын орчин, эрүүл ахуйн стандартыг батлуулж, хэрэгжүүлж эхэлнэ.	<ul style="list-style-type: none"> ❖ Сургууль байр орчны эрүүл ахуй, хоол хүнсний хангамжийн үйлчилгээ болон ус ариун цэврийн байгууламжийн аюулгүй байдлыг хангах, орчны стандартыг мөрдөх ❖ Сургуулийн суралцагчдын тоо, норм нормативт үндэслэн сургуулийн эмчийг орон тоогоор ажиллуулж, "Үдийн цай хөтөлбөр", дотуур байр, гал тогоо, спортын зал болон сургалтын орчны, эрүүл аюулгүй байдалд явцын үнэлгээг өдөр бүр 	<ul style="list-style-type: none"> ❖ Сургууль дотуур байрын орчны эрүүл ахуй, хоол хүнсний аюулгүй байдлын үнэлгээг "Бага эрсдэлтэй" түвшинд тогтмолжуулна. 	Сургууль байр орчны эрүүл ахуй, хоол хүнсний хангамжийн үйлчилгээ болон ус ариун цэврийн байгууламжийн аюулгүй байдлыг хангах, орчны стандартыг мөрдөж ажиллах талаар төлөвлөгөөгөө боловсруулан ажиллаж байна. 2018 оны хичээлийн жилд үдийн цай хөтөлбөрийн хүнсний бүтээгдэхүүнийг Номгон Рашаант ХХК, махыг Шувуутай –Оргил ХХК, сүү сүүн бүтээгдэхүүнийг иргэн О. Хүдэрчулуунтай гэрээлэн, хүүхдүүдэд	70

	ХИЙЖ ХЭВШИХ		шинжилгээтэй аюулгүй хүнсний бүтээгдэхүүнээр үйлчилж байна. Аймгийн Засаг даргын 2017 оны 538 дугаар захирамжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 5 дахь заалт, Эрүүл мэндийг дэмжих жилийн ажлын хүрээнд “Үдийн цай” хөтөлбөрт хамрагддаг 1-5 ангийн хүүхдүүдийн сүүний хэрэгцээг нэмэгдүүлэх зорилгоор “Өдөрт нэг аяга сүү” арга хэмжээг 9 сарын 12-ноос 10 сарын 12 хүртэл сарын хугацаанд хэрэгжүүлж тайлан мэдээг Дундговь аймгийн хөдөө аж ахуйн газарт хүргэлээ. Дотуур байр болон үдийн цай хөтөлбөрийн хоолны газар нь MNS 0900:2005 монгол улсын стандартын шаардлага хангасан шинжилгээтэй зөөврийн ундны усыг хүүхдийн эрүүл мэндэд эрсдэлгүй зориулалтын материалаар хийгдсэн зөөх хадгалах саваар авч, өдөр тутмын хэрэгцээндээ хэрэглэж байна. Ундны усны зөөврийн болон хадгалах савыг 7 хоногт 1 удаа бүрэн суллаж, хүнсний зориулалтын бодисоор угааж халдваргүйжүүлж хэвшлээ. Сургуулийн гаднах бохирын цооног, оо-д өт, авгалдай, ялаа, устгах ариутгах халдваргүйжүүлэлтийг хлорын шохойн 5% уусмалаар мэргэжлийн байгууллагаар 11 сард хийлгэлээ.	
12. Ерөнхий боловсролын сургуулийн орчин дахь хүүхэд хамгааллын бодлогыг	<ul style="list-style-type: none"> ❖ Сургуулийн хүүхэд хамгааллын нэгж, бодлогын баримт бичгийг багш ажилтан, эцэг эх олон нийт, сурагчдад танилцуулан, талуудын оролцоог ханган ажиллах ❖ Хүүхэд хамгааллын нэгжийг 	<ul style="list-style-type: none"> ❖ Хүүхэд хамгааллын нэгжийг шинээр томилон, нийт 34 багш ажилтан, 300 эцэг эхэд хүүхэд 	2018.10.11 – ний өдрийн А/23 тоот сургуулийн захирлын тушаалаар хүүхэд хамгааллын нэгжийг шинээр томилон үйл ажиллагааны төлөвлөгөөгөө боловсруулан ажиллаж байна. 2018 – 2019 оны хичээлийн жил	100

<p>хэрэгжүүлж, багш ажилтан, суралцагч, эцэг эх, асран хамгаалагчдад сэтгэлзүйн зөвлөгөө өгөх, дэмжин туслах, үйлчилгээ үзүүлэх чиглэлээр нийгмийн ажилтныг мэргэшүүлж, хамтран ажиллана.</p>	<p>захирлын тушаалаар шинэчлэн байгуулах ❖ Багш ажилтан, суралцагч, эцэг эх, асран хамгаалагчдад сэтгэлзүйн зөвлөгөө өгөх, дэмжин туслах, үйлчилгээ үзүүлэх чиглэлээр нийгмийн ажилтныг мэргэшүүлэх сургалтанд хамруулах.</p>	<p>хамгааллын бодлогыг танилцуулж, мэргэжлийн байгууллагатай хамтран 2 удаагийн сургалт мэдээллийг зохион байгуулсан байна.</p>	<p>эхлэснээр сурагчдын дунд хүүхдийн эрх хамгааллын чиглэлээр цахим орчны аюулгүй байдал, замын хөдөлгөөний дүрмийн мэдлэг, эерэг харилцаа хандлагын чиглэлээр Монголын эрэгтэйчүүдийн нийгэмлэг, Дундговь аймгийн цагдаагийн газрын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хэсэгтэй хамтран нийт 4 удаагийн сургалтыг зохион байгуулсан ба эцэг эхчүүдэд :</p> <ul style="list-style-type: none"> ❖ 2018.09.17 – нийт эцэг эхчүүдийн хурал /58 иргэн/ ❖ 2018.09.27 – эцэг эхийн зөвлөгөөн /41/ ❖ 2018.10.19 – 3 багийн нэгдсэн өдөрлөг буюу сургууль сурталчлах үйл ажиллагаа / 142 иргэн/ ❖ 2018.11.07 – Төрийн байгууллагуудын нээлттэй хаалганы өдөрлөг / 49 иргэн/ - өөр дамжуулан Хүүхэд хамгааллын шинээр байгуулсан нэгж, хамгааллын бодлого, гар утас цахим хэрэгслийг сургуулийн орчинд хязгаарлах, хүүхдийн хөгжил хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрийг тус тус танилцуулж, чухал шаардлагатай үед холбоо барих утасны жагсаалтыг нийт эцэг эхчүүдэд хүргэсэн. <p>Нийгмийн ажилтныг мэргэжил аргагүйг дээшлүүлэх чиглэлээр 2018.10 сард Хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр нийгмийн ажлын үйлчилгээ, сэтгэлзүйн тулгамдсан асуудалтай</p>
---	---	---	---

			хүүхэдтэй ажиллах, хүний эрх ба хүн худалдаалах гэмт хэргийн хор уршиг, түүнээс урьдчилан сэргийлэх мэргэжил аргагүйн дэмжлэг үзүүлэх 16 цагийн бүсийн сургалт, 2018.11 сард ӨМӨЗО – ы Баяннуур аймагт туршлага судлах аялалд тус тус хамрууллаа.	
13. Анги удирдсан багш хүүхдийн хөгжил, хүмүүжил төлөвшлийн асуудлаар эцэг эх асран хамгаалагчдад зөвлөн туслах ажлыг тогтмолжуулж, үр дүнг сайжруулна.	<ul style="list-style-type: none"> ❖ Өрхөөр зочлох судалгаат ажлыг тогтмолжуулж, эцэг эх, асран хамгаалагчдын саналыг авах ❖ Хүүхэдтэй холбоотой аливаа асуудлыг хүлээн авах нээлттэй утасны жагсаалтыг эцэг эх, асран хамгаалагчдад танилцуулж, 24 цагаар өргөдөл гомдол, санал хүсэлтийг хүлээн авч хэвших. ❖ Анги удирдсан багш бүр Боловсролын салбарын мэдээллийн системийн "Эцэг, эхийн дэд систем"-д эцэг эхчүүдийг заавал холбож, ашиглалтыг сайжруулан, сургалтын менежерүүд хяналт тавих ❖ Эцэг эх, асран хамгаалагчдад зориулсан хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга барилын сургалт мэдээллийн үйл ажиллагааг эцэг эхийн хурлаар дамжуулан хүргэх. 	<ul style="list-style-type: none"> ❖ Анги тус бүр эцэг эхийн хурлыг 3 удаа, сургалт мэдээллийг 2 удаа, цахим бүртгэлд бүх эцэг эхчүүдийг хамруулсан байна. 	Нийт 9 бүлгийн 138 суралцагчийн ар гэрийн нөхцөл байдлын үнэлгээ, өвөлжилтийн бэлтгэл хангалтын болон эрсдэлийн судалгааг анги удирдсан багш нартай хамтран авч, 2018.10 сард 8 зүйл бүхий “Хүүхдийн хөгжил хамгаалал, аюулгүй байдлыг ханган ажиллах зөвлөмж” – ийг эцэг эх, асран хамгаалагчдад нэг бүрчлэн танилцуулж, цахим орчны аюулгүй байдлын санамж бичигт 5 – 9 ангийн нийт сурагч, эцэг эх, анги удирдсан багш нар гарын үсэг зурлаа. Хүүхэд хамгааллын бодлого, гар утасны хэрэглээг хязгаарлах тухай засгийн газрын тогтоол, БСШУСЯамны сайдын тушаал, боловсролын байгууллагын сургалтын орчин, дотуур байранд хүүхэд хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх журмуудыг ангийн хурал болон нийтийг хамарсан үйл ажиллагаагаар дамжуулан эцэг эхчүүдэд бүрэн танилцуулаад байна.	70
14. Албан бус, насан туршийн боловсролын үйлчилгээний бүтэц, тогтолцоог боловсронгуй болгож, бүх насны	<ul style="list-style-type: none"> ❖ “Насан туршийн боловсролын төв”-ийн үйл ажиллагаа, чанар хүртээмжийг сайжруулж, сурах бичиг, хэрэглэгдэхүүн, сурах орчныг сайжруулан иргэдийн боловсролыг дээшлүүлэх ❖ Хөгжлийн бэрхшээлтэйн улмаас 	<ul style="list-style-type: none"> ❖ Бичиг үсэг үл мэдэгчдийн тоог 28 – 20 хүргэх ❖ Цэргийн насны суурь боловсрол эзэмшээгүй 6 иргэнийг БЗДарга 	Энэ хичээлийн жилд албан бус насан туршийн боловсрол нэгжийн дүйцсэн хөтөлбөрийн сургалтанд нийт 6 суралцагчаас бага боловсролд 3, суурь боловсролд 3 суралцагч суралцаж байна.Суралцагч нарт танхимаар болон зайны сургалтаар боловсролын	70

<p>хүн ам насан туршдаа суралцах чиглэлээр цахим контентийг хөгжүүлж эхэлнэ.</p>	<p>болон бусад шалтгаанаар сургууль завсардаж бичиг үсэгт тайлагдаагүй хүүхдийг бичиг үсэг тайлагдах сургалтанд хамруулах</p> <p>❖ Цэргийн насны залуучуудын бичиг үсгийн боловсролыг дээшлүүлэх ажлыг багийн Засаг дарга нартай хамтран зохион байгуулах</p>	<p>нартай хамтран дүйцсэн хөтөлбөрт болон бичиг үсгийн боловсрол дээшлүүлэх сургалтанд хамруулах</p> <p>❖ Дүйцсэн хөтөлбөрийн нэгдсэн цугларалтыг 1 удаа зохион байгуулсан байна.</p>	<p>гаднах үйлчилгээг хүргэж, багийн засаг дарга болон эцэг эх асран хамгаалагч нараар дамжуулан сургалтын материал гарын авлага, гэрийн даалгавар зэргийг хүргүүлэн ажилласан.</p> <p>Бичиг үсгийн боловсрол олгох сургалтанд нийт 8 суралцагч хамрагдаж байгаагаас анхан шатанд - 3, ахисан түвшинд 2, дунд шатанд 3 суралцагч суралцаж байна.Сургалтаар амьдрах ухаан болон бичиг үсгийн боловсрол олгох шаталсан модуль сургалтуудыг явуулын болон зайны хэлбэрээр явуулж байна.Суралцагч бүрээр ахиц өөрчлөлтийн хөтөлгөө болон үр дүн хэрэгжилтийг сургалтын мененжерээр хянуулан дүгнэн ажилласан.Цэргийн насны залуучуудын судалгаан дээр үндэслэн дүйцсэн хөтөлбөрийн болон бичиг үсгийн боловсрол олгох сургалтанд цэргийн насны нийт 4 суралцагч хамрагдаж байгаагаас бага боловсрол 3, суурь боловсролд 1 суралцагч хамрагдсан.</p> <p>Албан бус насан туршийн боловсролын үйлчилгээ хүртээмжийг нэмэгдүүлэхийн тулд цахим орчныг ашиглан сургуулийн болон өөрийн цахим хуудас нээж иргэдэд хэрэгцээтэй мэдлэг, мэдээлэл зэргийг байршуулж хэвшсэн.</p>	
<p>Эцэг эх асран хамгаалагчдын түвшинд : Хүүхдийн нас, хөгжлийн онцлог, зан төлөвийг таньж мэдэн, хүүхдээ ойлгож дэмжин туслах замаар боловсрол эзэмших, авьяас чадвараа хөгжүүлэхэд бүх талын дэмжлэг үзүүлнэ.</p>				
<p>15. Хүүхдээ хараа хяналтгүй орхихгүй байх, тэдний эрүүл</p>	<p>❖ Хүүхдээ хараа хяналтгүй орхихгүй байх, тэдний эрүүл мэнд, аюулгүй байдалд байнга анхаарал тавьж, хичээлийн хэрэгсэл, дүрэмт</p>	<p>❖ Эцэг эхчүүдэд чиглэсэн сургалт нөлөөллийн үйл ажиллагааг</p>	<p>Эцэг эхчүүдийн сурган хүмүүжүүлэх боловсролыг дэмжих чиглэлээр :</p> <p>❖ 2018.09.17 – нийт эцэг эхчүүдийн хурал /58 иргэн/</p>	<p>100</p>

<p>мэнд, аюулгүй байдалд байнга анхаарал тавьж, хичээлийн хэрэгсэл, дүрэмт хувцсаар хангах эцэг эхийн үүргээ хариуцлагатайгаар биелүүлнэ.</p>	<p>хувцсаар хангах эцэг эхийн үүргээ хариуцлагатайгаар биелүүлэхэд нь зөвлөн туслах, сургалт мэдээллээр ханган хамтарч ажиллах.</p>	<p>улирал бүрт 1 удаа мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулна.</p>	<ul style="list-style-type: none"> ❖ 2018.09.27 – эцэг эхийн зөвлөгөөн /41/ ❖ 2018.10.19 – 3 багийн нэгдсэн өдөрлөг буюу сургууль сурталчлах үйл ажиллагаа / 142 иргэн/ ❖ 2018.11.07 – Төрийн байгууллагуудын нээлттэй хаалганы өдөрлөг / 49 иргэн/ - өөр дамжуулан Хүүхэд хамгааллын шинээр байгуулсан нэгж, хамгааллын бодлого, гар утас цахим хэрэгслийг сургуулийн орчинд хязгаарлах, хүүхдийн хөгжил хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрийг тус тус танилцуулж, чухал шаардлагатай үед холбоо барих утасны жагсаалтыг нийт эцэг эхчүүдэд хүргэсэн. 2018.10 сард 8 зүйл бүхий “Хүүхдийн хөгжил хамгаалал, аюулгүй байдлыг ханган ажиллах зөвлөмж” – ийг эцэг эх, асран хамгаалагчдад нэг бүрчлэн танилцуулж, цахим орчны аюулгүй байдлын санамж бичигт 5 – 9 ангийн нийт сурагч, эцэг эх, анги удирдсан багш нар гарын үсэг зурлаа. 	
<p>16. Хүүхэд залуучуудад нэгдмэл шаардлага тавьж, хүмүүжил төлөвшилд нь үлгэр дууриал үзүүлнэ.</p>	<ul style="list-style-type: none"> ❖ Эцэг эхийн зөвлөгөөн, сургалт, мэдээллийн үйл ажиллагааг улирал тутам зохион байгуулж, хүүхдийн хүмүүжил төлөвшлийн чиглэлээр нэгдсэн нэг ойлголтонд хүрэх. 			
<p>Бусад</p>				
<p>17. Улс, Аймаг болон сумаас хэрэгжүүлэн ажиллаж буй бодлогын баримт бичиг, үндэсний хөтөлбөр, үйл ажиллагаануудын</p>	<ul style="list-style-type: none"> ❖ Улс, аймаг, сумын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх төлөвлөлт ❖ Шат шатны засаг дарга, төсвийн шууд захирагч нартай байгуулсан үр дүнгийн гэрээнд тусгагдсан боловсролд хамаарагдах заалтууд ❖ Байгууллага дээр хэрэгжиж буй үндэсний хөтөлбөрүүд 	<ul style="list-style-type: none"> ❖ Улс, аймаг, сумаас хэрэгжүүлэн ажиллаж буй бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийг 100 хувь хугацаанд нь 	<p>Улс, Аймаг болон сумаас хэрэгжүүлэн ажиллаж буй бодлогын баримт бичиг, үндэсний хөтөлбөр, үйл ажиллагаануудын хэрэгжилтийг ханган, хагас ба бүтэн жилээр тайлан нэгтгэлийг ЗДТГ, БСУГ – т тус тус хугацаанд нь хүргүүлэн ажиллаж хэвшсэн.</p>	<p>100</p>

хэрэгжилтийг ханган ажиллах	❖ Хүний нөөцийг бэхжүүлэх, ил тод байдлыг хангах, сахилга хариуцлагыг сайжруулах чиглэлээрх үйл ажиллагаануудыг хэрэгжилтийг хянан, тайлан мэдээг хугацаанд нь холбогдох байгууллага албан тушаалтанд хүргүүлэн ажиллах	хүргүүлж, гүйцэтгэлийг тогтмол 80 дээш хувьд хүргэнэ.		
Нийт хэрэгжилтийн хувь 79,3				

Сургуулийн захиргаа